

Удирдах зөвлөлийн 2024 оны 05 дүгээр сарын 02-ны өдрийн

02 дугаар тогтоолын хавсралт



ХӨДӨЛМӨРИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ЭРҮҮЛ АХУЙН ЗӨВЛӨЛИЙН АЖИЛЛАХ ЖУРАМ

ҮУПК- УББ-ЖУ -06- 2024

Нэг. Ерөнхий зүйл

1.1. Байгууллагын хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн зөвлөлийн үйл ажиллагааны зорилго нь багш ажиллагсдын хөдөлмөрийн нөхцөл, суралцагчдын сургалтын орчныг сайжруулах үйлдвэрлэлийн осол, хурц хордлого, мэргэжлээс шалтгаалах өвчнөөс урьдчилан сэргийлэх ажлыг зохих шаардлагын дагуу зохион байгуулахад оршино.

1.2. Зөвлөл нь Хөдөлмөрийн тухай хууль, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль болон энэхүү журмыг удирдлага болгон үйл ажиллагаагаа явуулна.

Хоёр. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн зөвлөлийн зохион байгуулалт, түүний бүрэн эрх

2.1 Зөвлөл нь 11 гишүүнтэй байна. Зөвлөлийн дарга, нарийн бичгийн даргыг 2 жилийн хугацаатай сонгох бөгөөд улиралд 1-ээс доошгүй удаа хуралдана. Зөвлөл нь үйл ажиллагааныхаа тайланг байгууллагынхаа хамт олонд хагас, бүтэн жилээр жилд 2 удаа тайлагнана.

2.2 Зөвлөл нь Хөдөлмөрийн тухай хууль, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн чиглэлээр гарсан олон улсын хөдөлмөрийн байгууллагын дүрэм, журмууд бусад хууль эрхзүйн актууд, энэ журмыг удирдлага болгон ажиллана.

2.3 Зөвлөл нь өөрийн чиг үүрэгтэй холбогдуулан зөвлөмж гаргана. Зөвлөлөөс гаргасан зөвлөмжийг алба, нэгжүүдийн удирдлага, нийт багш ажилчид биелүүлэх үүрэгтэй.

Гурав. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн зөвлөлийн гүйцэтгэх үүрэг, эрх

3.1 Зөвлөлийн үүрэг

3.1.1 Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн чиглэлээр тухайн жилд хэрэгжүүлэх үйл ажиллагааны нэгдсэн төлөвлөгөөг боловсруулан батлуулж, хэрэгжилтийг ханган ажиллах.

3.1.2 Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн асуудлаар санал боловсруулж ажил олгогч, ажилтны төлөөлөлд хүргүүлэх.

3.1.3 Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн менежментийн системийн хүрээнд нийт ажилтан, суралцагчдад мэдлэг дээшлүүлэх сургалт зохион байгуулах, үйл ажиллагааг сайжруулах санал, зөвлөмж гаргах.

3.1.4 Ажлын байр, хөдөлмөрийн нөхцөлд хөдөлмөрийн аюулгүй байдлын үзлэг хийж гарсан үр дүнг ажил олгогч болон ажилтнуудад мэдээллэж хууль, дүрэм, стандартын шаардлагад нийцүүлэх чиглэлээр зөвлөмж хүргүүлэх.

3.1.5 Ажлын тусгай хувцас, хамгаалах хэрэгслийн хангалт, хэрэглээ, ариун цэвэр, эрүүл ахуйн стандарт хангалт, багш суралцагчдын эрүүл мэндийн үзлэгт хамрагдсан байдал, түүний мөрөөр хийгдсэн ажил, сургалтын дадлагын газруудад үзлэг хийж үр дүнг нь хамт олонд мэдээллэх.

3.1.6 Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн хууль тогтоомжийг сурталчлах, сэрэмжлүүлэх, хууль, дүрэм, журам, стандартыг мөрдөх талаар нийт ажилтан, суралцагчдын үүрэг хариуцлагыг өндөржүүлэх, хөдөлмөрийн сахилгыг бэхжүүлэх үйл ажиллагаанд оролцох.

3.1.7 Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн талаар ажилтан, суралцагчдын гаргасан санал хүсэлтийг шийдвэрлүүлэх талаар ажил олгогчид зөвлөмж өгөх.

3.2 Зөвлөлийн эрх

3.2.1 Ажлын байр хөдөлмөрийн болон сургалтын орчинд үзлэг шалгалт хийх ажилд ажил хариуцсан албан тушаалтан, мэргэжлийн багш ажилтнуудыг татан оролцуулах, мөн сургалтын орчны хөдөлмөрийн нөхцөл, үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчин, хурц хордлого, аюултай, хортой хүчин зүйлийн талаар мэдээлэл гаргуулан авах.

3.2.2 Алба, нэгжийн удирдлагуудад хөдөлмөрийн аюулгүй байдал, ажлын байр /сургалтын орчин/ -ны нөхцөлийг сайжруулах, гарч болзошгүй осол, эндэгдэл, өвчлөлөөс сэргийлэх талаар шаардлага тавих.

3.2.3 Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн хууль тогтоомж зөрчсөн албан тушаалтан, ажилтанд хариуцлага хүлээлгэх талаар ажил олгогчид санал тавин шийдвэрлүүлэх.

3.2.4 Байгууллагын захиргаанд хөдөлмөрийн эрүүл, аюулгүй нөхцөлийг бий болгоход идэвх санаачлагатай ажилласан хувь хүн, хэсэг, хамт олныг урамшуулах санал оруулах.

3.2.5 Шаардлагатай тохиолдолд аюулгүй ажиллагааны талаар гарсан хууль, тогтоомж, дүрэм, журам илт зөрчигдсөн ажлын байрыг түр хугацаагаар хаах, үйл ажиллагааг нь зогсоох талаар холбогдох дээд шатны албан тушаалтан байгууллагад мэдэгдэх.

Дөрөв. Хариуцлага

4.1 Зөвлөлийн гишүүд нь Хөдөлмөрийн тухай хууль, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн чиглэлээр гарсан олон улсын хөдөлмөрийн байгууллагын дүрэм, журмууд, бусад хууль эрхзүйн актууд, энэ журмыг ханган ажиллаагүй тохиолдолд хариуцлага хүлээнэ.
